



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 635.

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9 нэрийн, нийт 96,392,000 (ерэн зургаан сая гурван зуун ерэн хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 19,278,400 (арван есөн сая хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулган нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000635

28-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12 өдрийн
635 дугаар тогтоолын хавсралт

"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮНЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА СУНГАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа		
						Цаашид ашиглах жил	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Ширээ /сэтгүүлийн /	2014/04/30	ш	1	240,000.00	2	48,000.00	48,000.00
2	Төмөр шүүгээ	2014/05/16	ш	1	344,000.00	2	68,800.00	68,800.00
3	Сервер шүүгээ	2014/06/04	ш	1	198,000.00	2	39,600.00	39,600.00
4	Электрон теодолит	2013/10/01	ш	1	1,880,000.00	2	376,000.00	376,000.00
5	Автомат нивелер	2013/10/01	ш	1	730,000.00	2	146,000.00	146,000.00
6	Шмитийн алх	2013/12/01	ш	1	16,500,000.00	2	3,300,000.00	3,300,000.00
7	Арматур хэмжигч	2013/12/01	ш	1	20,000,000.00	2	4,000,000.00	4,000,000.00
8	Ханын цууралт тодорхойлогч	2013/12/01	ш	1	8,500,000.00	2	1,700,000.00	1,700,000.00
9	Hyundai Azera 08-47 УНУ	2013/06/01	ш	1	48,000,000.00	2	9,600,000.00	9,600,000.00
ДҮН					96,392,000.00 (ерэн зургаан сая гурван зуун ерэн хоёр мянга)			19,278,400.00 (арван есөн сая хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун төгрөг)